



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

04.27 - 05.01



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Коронавирусын тархалтын эсрэг үр дүнтэй алхмууд хийгдэж байгаа хэдий ч эдийн засгийн үзүүлэлтүүд муу гарсан болон худалдааны дайн буцаад эхлэх боломжтой байгаагаас үүдэн энэ долоо хоногт хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй хаагдлаа. 4-р сард томоохон индексүүд 1987 оноос хойших хамгийн их хэмжээгээр өссөн байна. Зах зээлийн үнэлгээ багатай компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан ба зарим улсад газрын тосны хэрэглээ эргээд сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор S&P 500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбар хамгийн их өсөлттэй байлаа. Харин эрүүл мэндийн салбар болон ус, дулаан, цахилгаан хангамжийн салбар уналттай байлаа.

АНУ-ын зарим мужууд болон зарим нэг томоохон эдийн засгууд коронавирусын хөл хориогоо дуусгаж эхэлснээр энэ долоо хоногт хөрөнгө оруулагчдын хандлага харьцангуй эерэг байлаа. Зарим бүс нутгуудад коронавирусын өвчлөл буурч, эмчилгээний үйл ажиллагаа сайжирч байгаа боловч АНУ-ын шинэ тохиолдлын ерөнхий түвшин буурахгүй хэвээр байна.

Европ: Хөл хориогийг тавих талаар мэдээллийг хөрөнгө оруулагчид эергээр хүлээн авч, Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Гэвч, Европын Төв Банк эдийн засгийг сэргээх хөтөлбөрт зориулж нэмэлтээр төсөв батлахгүй гэсэн шийдвэр нь тус өсөлтийг бууруулжээ. STOXX Europe 600 индекс 2.60%, DAX индекс 5.08%, CAC 40 индекс 4.07%, FTSE MIB индекс 4.93%, FTSE 100 индекс 0.19% тус тус өссөн байна.

Европын Төв Банк бодлогын хүүгээ -0.5% хэвээр хадгалахаар болж, санхүүгийн зах зээлийг уналтаас сэргийлэхийн тулд 1 тэрбум еврогийн бонд худалдан авах хөтөлбөрөө хэрэгжүүлнэ гэдгээ мэдэгджээ. Түүнчлэн, 6-р сараас эхлэн банкнуудыг дэмжих зорилгоор -1% хүүтэй зээл олгож, зорилтот урт хугацааны дахин санхүүжилтийн үйл ажиллагааг [targeted longer-term refinancing operations (TLTROs)] эрхлэхээр болжээ. ЕТБ-ны ерөнхийлөгч Кристин Лагарде, евро бүсийн санхүүгийн системийн хөрвөх чадварыг сайжруулах, мөнгөний зах зээлийн үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд -0.25% хүүтэй зээл олгож, евро бүст амьдарч буй бүх иргэдээ дэмжихийн тулд чадах бүхнээ хийхээ амласан ба зохистой сангийн байр суурьтай байх нь маш чухал гэж мэдэгджээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд 5-р сарын 1-ны огцом уналтыг эс тооцвол харьцангуй өсөлттэй хаагдлаа. Лхагва гарагт 1989 онд өөд болсон Японы эзэн хаан асан Шовагийн (Showa) төрсөн өдөр болж бүх нийтийн амралтын өдөр болсон байна. Nikkei 225 Stock Average индекс 357 пункт буюу 1.9% өсөлт үзүүлж 19,619.35 болсон боловч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 17.1% бага байгаа юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээл энэ долоо хоногийн Баасан гаригаас эхлэн дараа долоо хоногийн Лхагва гараг буюу 5-р сарын 6-н хүртэл Хөдөлмөрийн Өдрийн амралттай байх юм байна. CSI 300 large-сар индекс 3.0%, харин Шанхай Composite индекс 1.8% тус тус өссөн байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,507.69	2.20% ▲
Dow Jones	АНУ	23,723.69	-0.22% ▼
S&P 500	АНУ	2,830.71	-0.21% ▼
Nasdaq	АНУ	8,604.95	-0.34% ▼
S&P/TSX	Канад	14,620.34	1.39% ▲
FTSE 100	Их Британи	5,763.06	0.19% ▲
S&P/ASX 200	Австрали	5,245.90	0.06% ▲
Nikkei 225	Япон	19,619.35	1.86% ▲
Hang Seng	Хонг Конг	24,643.59	3.41% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	96.35
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	89.00
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	89.31
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	99.03
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.05
DBM' 2023	USD	7.250%	87.49
TDBM' 2020	USD	9.375%	99.85
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	78.53

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.303	-0.14 ▼
Libor 3M	0.541	-0.35 ▼
Libor 6M	0.713	-0.21 ▼
Libor 1YR	0.836	-0.10 ▼
US 2YR Bond	0.190	-0.03 ▼
US 3YR Bond	0.237	-0.03 ▼
US 5YR Bond	0.350	-0.03 ▼
US 10YR Bond	0.612	0.00 ▼

Валютын ханш	2020.05.01	Өөрчлөлт
USD	2,788.93	0.12% ▲
CNY	394.91	0.41% ▲
EUR	3,057.92	2.20% ▲
RUB	37.02	-0.83% ▼
KRW	2.28	0.88% ▲
JPY	26.08	0.85% ▲
CAD	1,986.70	0.48% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,700.42	-1.69% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	14.98	-1.82% ▼
Зэс	USD/lb.	231.20	-1.05% ▼
Нүүрс	USD/MT	53.20	-4.06% ▼
WTI газрын тос	USD/bbl.	19.78	16.77% ▲
Brent газрын тос	USD/bbl.	26.44	23.32% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. III	6.4%
Бодлогын хүү	2020. III	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. III	10.18%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. III	11.41%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. III	4.67%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. III	17.07%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. III	10.34%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 1,328.7 сая төгрөгийн 3,920,400 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Гутал” /GTL/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 19,780.00 төгрөг хүрч хаагдсан бол “Стандарт агрикалчер групп” /SOH/ компанийн хувьцаа 33.58%-аар буурч 41.62 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

05-р сарын 01-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,432.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,507.69 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.20%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,328.7	
Зах зээлийн үнэлгээ	2,432,460.0	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,507.69	2.20% ▲
MSE I индекс	7,715.46	2.81% ▲
MSE II индекс	7,508.56	1.74% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Фронттиер Лэнд Групп	2,137,799	641,339,700
Жуулчин Дюти Фрий	2,164	173,058,000
АПУ	246,264	132,926,939
Дархан Нэхий	6,560	85,282,700
Ариг Гал	22,437	64,957,660

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Гутал	19,780.00	15.00% ▲
Би Ди Сек	1,030.00	14.96% ▲
Хөвсгөл усан зам	494.00	14.82% ▲
Баянгол зочид буудал	31,000.00	14.81% ▲
Шарын гол	977.00	12.04% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Стандарт агрикалчер групп	41.62	-33.58% ▼
Дархан гурил тэжээл	3,613.00	-27.74% ▼
Улсын их дэлгүүр	900.00	-13.88% ▼
Дөрвөн-Уул	690.00	-13.75% ▼
Агротехимпекс	700.00	-9.09% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Евразиа Капитал Монголиа	1,282,879,400.00
Аргай Бэст	381,794,437.00
Стандарт Инвестмент	381,754,586.35
Би Ди Сек	331,192,034.93
Ард Секюритиз	83,790,586.19

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	539.99	574,647
Таван толгой	5,000.00	263,326
МИК Холдинг	11,000.00	227,803
Инвескор ББСБ	2,516.00	180,467
Говь	200.66	156,537

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монгол Улсын 2012 оны 4-р сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцаатай холбоотой олон нийтийн цахим сүлжээнд худал ташаа мэдээлэл, сурталчилгаа тавигдах боллоо.

Тухайлбал facebook олон нийтийн сүлжээнд “1072 хувьцаа авна”, “1072 хувьцаа бэлэн мөнгөөр авна”, “1072 хувьцаа худалдаж авна, данс нээнэ” гэх зэрэг зар мэдээлэл нь иргэд, олон нийтийг залилан мэхэлж болзошгүй гэмт хэргийн шинжтэй, зөвхөн пэйж хуудсаа олон хүний хандалттай болгох гэсэн зорилготой үйлдэл гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа нь захиран зарцуулахгүй байх нөхцөлтэй буюу арилжаалагдах, бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд Хорооны үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д хандан 1,072 хувьцаатай холбоотой мэдээ, мэдээллийг авах боломжтой.

Иймд иргэд та бүхэн 1,072 хувьцаатай холбоотой цахим сүлжээн дэх албан бус мэдээлэл, сурталчилгаанд хууртагдахгүй байх, бусдад залилан мэхлүүлэхгүй байхыг сэрэмжлүүлж байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

Covid-19-ийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 05-р сарын 01-ний байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийхээр шийдвэрлэсэн байна Үүнд:

1. “Улсын Их Дэлгүүр” ХК 2020 оны 4-р сарын 30-ны өдрийн 10:00 цагт
2. “Женко Тур Бюро” ХК 2020 оны 5-р сарын 13-ны өдрийн 09:30 цагт

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Даваа гарагт “Фронтинер лэнд групп” ХК-ны нийт хувьцааны 15.6% арилжигдав

“Фронттер лэнд групп” /MSE:MDR/ ХК-ийн 2,137,799 ширхэг хувьцаа нэг бүр нь 300 төгрөгийн ханш дээр арилжигдсан томоохон арилжаа явагдлаа. Тус компанийн нийт гаргасан хувьцааны 15.6%-тэй тэнцэх уг хэлцэл нийтдээ 641.3 сая төгрөгийн үнийн дүнд хийгдсэн юм.

Энэ нь сүүлийн сарын хугацаанд хийгдэж буй 2 дахь том хэлцэл бөгөөд одоогоос 1 сарын өмнө мөн 15.3% нь арилжигдаж байсан

Эх сурвалж: MarketInfo.mn

“Тавантолгой” ХК цэвэр ашгийнхаа 90 хувийг ногдол ашигт хуваарилна

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Тавантолгой” ХК 2019 оны үйл ажиллагааны цэвэр ашгийнхаа 90 хувийг ногдол ашиг болгон тараахаар болсон байна.

2019 онд 664.1 сая төгрөгийн орлого олж, 6.1 сая төгрөгийн буюу нэгж хувьцаандаа 81.59 төгрөгийн ашигтай ажиллажээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Анд энерги” ХК 2020 онд ашгийн хэмжээг 10 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөв

“Анд энерги” /MSX:AND/ ХК 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 4-р сарын 25-ны өдөр хуралдуулж, үйл ажиллагааны үр дүнгээ танилцуулав.

Орхон аймагт лед гэрэл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй тус компани өнгөрөгч онд нийт 25,700 ширхэг гэрэл үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна.

Санхүүгийн хувьд мөн онд 1.38 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласнаас 923.4 сая төгрөгийг гэрэлийн борлуулалтаас, 456.5 сая төгрөгийг бусад ажил үйлчилгээнээс олжээ.

Цэвэр ашиг 22.9 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 0.3 төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 32%-аар буурав. Ашиг буурахад үйлдвэр, оффисын шинэ барилгаа ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмжүүдээ угсрахтай холбоотой байсан гэж компани мэдээлэв.

Харин 2020 онд “Анд энерги” /MSX:AND/ ХК-ийн зүгээс зах зээлд хэд хэдэн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, гэрэлийн борлуулалт, ажил үйлчилгээг нэмэгдүүлж, борлуулалтын орлогоо 76%-аар, цэвэр ашгийг 10 дахин өсгөхөөр төлөвлөсөн байна. Энэ нь 1-р улирлын санхүүгийн үр дүнгээс биелэх боломжтой байна гэж Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр мэдэгдлээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Дэлхийн банк Монгол Улсад олгох 53 сая ам.долларын санхүүжилт баталлаа. Үүнээс 41 сая нь Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөлд зориулагдана.

Энэхүү төслийн хүрээнд төвлөрсөн дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх, дулаалга муутай, дулаан алдаж буй шугам хоолой, шахах станцуудыг шинэчлэх ажил төлөвлөжээ. Харин “Тогтвортой амьжиргаа-III” төсөлд 12 сая ам.долларын нэмэлт санхүүжилт хийхээр болсон байна. Энэхүү санхүүжилтийг Монгол Улсын 330 суманд орон нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулахад зарцуулах аж.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк сар тутмын статистик, эдийн засгийн нөхцөл байдлын талаар танилцууллаа. Оны эхний улиралд төлбөрийн тэнцэл 350.2 сая ам.долларын алдагдалтай гараад байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 570 гаруй сая ам.доллароор муудаад байгаа юм. Алдагдалд экспортын орлого огцом муудсан нь үндсэн шалтгаан болсныг тайлбарлаж байна.

Гаалийн ерөнхий газрын мэдээллийг харвал оны эхний гурван сард экспорт өмнөх оны мөн үеэс 42%-аар буурчээ. Энэ нь мөнгөн дүнгээр 736 сая ам.доллар болж байна. Төлбөрийн тэнцэл муудахтай зэрэгцээд гадаад валютын албан нөөц 300 орчим сая ам.доллароор буурч, дөрвөн тэрбум ам.доллар хүрлээ. Харин орох урсгалыг харвал гадаадын шууд хөрөнгө оруулалтын нэг мега төслөөс хамаарах хамаарал маш өндөр байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Тавантолгой” ХК 2020 он гарснаас хойш нийт 600 орчим мянган тонн нүүрс борлуулаад байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ нь ойролцоогоор хоёр дахин буурсан гэдгийг тус компани мэдээллээ. “Тавантолгой” ХК-ийн нүүрсний олборлолт, борлуулалт хэвийн үргэлжилж байгаа ч хөрс хуулалтын ажлаа 4-р сарын 16-наас эхлэн зогсоожээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.